2021 оны 02 сарын 02-ны өдөр Дугаар А/54 Улаанбаатар хот

Захиалагчийн хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль журамд нийцсэнийг үндэслэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/-т, хавсралтын 1 дэх хэсэгт тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл технологийн газар /О.Чинзориг/-т, 2 дахь хэсэгт тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ /Д.Одбаяр/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /М.Баяраа/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 02-ны өдрийн
А/54 дүгээр захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ОН ДАМЖИН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/Төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих дүн
1	**Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем** Телехяналтын камеруудыг нэгдсэн шилэн кабелийн сүлжээнд холбох /Эмээлт, Баруун туруун, Морин даваа, Өлзийт, Налайх, Гачуурт, Гүнт, Долоон буудал/	2020-2022	798,732,300	336,285,031
2	**Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем** Замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионы системийг сайжруулан шинэчлэх ажил	2020-2022	388,850,000	163,714,969
	ДҮН		1,187,582,300	500,000,000